

ТАТАРЫН ТАЛХИН ДОР

Орос, Алтан Ордны Улс. Зохиогч нь Чарльз Ж. Галперин. Хэвлэлийн
И. Б. Таурис пүүс, Лондон, үнэ дурьдаагүй (он байхгүй)

Том ард түмнүүдийн хоорондох ширүүн өрсөлдөөн их төлөв ижил төстэй түүхэн замналаас үүсдэгийг Иран-Ирак, Япон-Солонгос, Англи-Францын бие биеийн эсрэг явуулж ирсэн зөрчил тэмцэл харуулж байна. Гэтэл Хятад, Оросын хувьд бол хараахан тийм биш юм. Ийм том хоёр ард түмэн тийм өргөн газраар хил залгаа оршдог мөртөө хэлхээ холбоо тун багатай явж ирсэн нь бишгүй билээ. Хятад, Орос хоёрын хуваалцаж ирсэн хамгийн нийтлэг хүчирхэг түүхэн туршлага нь магадгүй коммунизм бус, харин аль аль нь мартахыг хичээх буюу үгүй дээ маш бүдэг өнгөөр будахыг оролддог Хятадад 140 жил, Орост 240 жил үргэлжилсэн Монголчуудын ноёрхол юм.

Хэдийгээр нийтлэг шинжтэй боловч Орос, Хятад хоёрыг Монголчууд заагтай үздэг. Тэд болон төв Азийн бусад ард түмнээс Орос, Хятадын эзэнт улсуудад одоо ч залгигдсан хэвээр байх боловч энэ хувирч болохгүй зүйл огт биш ээ.

Чарльз Ж. Галперины номд Монголын довтолгоо оросуудад хэрхэн нөлөөлснийг болон тэд (оросууд) Монголын дөрвөн ханилаг болон хуваагдсан Чингис хааны агуу их эзэнт гүрний нэг ханилаг болох Алтан ордны улсад 240 жил захирагдсан түүхийг дүрслэн харуулахыг хичээжээ, Монголын үе нь Орос угсаатны оюун санаа, тэдний Византи гаралтай Христос шашны аль аль нь нухчин дарлагдсан үе гэж хувьсгалын өмнөх болон хойшхи үеийн Оросын түүхчид нэлэнхүйдээ зэмэлдэг юм. Тэр ч байтугай «Татарын талхины» урт шөнө гэдэг зүйр үг ч гарчээ. (Татар нь Монгол, Түрэг нүүдэлчин ард түмний нийтлэг нэр болно). Гэтэл хэрэг явдлын учир утга их л нарийн юм.

Балтийн тэнгис хүртэлх одоогийн Төв Орос, Украин, цаашилбал одоогийн Польшийн чиглэлээр хийсэн Монголчуудын анхны дайралт довтолгоо Хятад, Персийн эзэнт улсуудын нутгийг эзэлснийхээ нэг адил газар тариалан, хот тосгодыг талж дээрэмдэн, шатаан түймэрдэж үй олон хүнийг эрэмдэг зэрэмдэг болгожээ. Гэхдээ орон нутгийн вангууд байлдан дагуулагчдын талд орж дэмжлэг үзүүлж байснаас шалтгаалан Оросын зарим нутаг район онцгой их хэлмэгджээ.

Хятадад Монголчууд Ханбалгас (Бээжингийн Монгол нэр)-д нийслэлэн суурьшиж тэндээс эзэнт гүрнийг шууд захирч байв. Тэд Хятад, Перс хоёрт тэндэхийн ганган бичгийн урлаг, яруу найрагт дасан дассаар яваандаа харин өөрсдийнхөө олз олборт идэгджээ.

Гэтэл Оросын хувьд бол ялгаатай байв. Орост тэд колоничлогчийн журмаар нутаглаж суурьшсангүй, шинэ язгууртан болж дээрэлхсэн ч үгүй. Энэ тухайн хэд хэдэн шалтгаан ч байна. Тухайлбал, тал нутгийн Монголчуудад Славчуудын ой шугуйт нутаг таалагдаагүй ч байж болох юм. Хятадад суурьшиж, идээшиж болсон гэхэд Орост тийнхүү худалдаа, соёл иргэншлийн талаар татагдах зүйл хангалттай

*Russia and the Golden Horde, by Charles J. Halperin. I. B. Tauris & Co., London,

бус байсан ч юм уу, эсвэл шууд захирахад тохиромжтой засаг захиргааны систем бүрэлдэж хөгжөөгүй байсан тал ч байж мэднэ. Ямар ч байлаа гэсэн Монголчууд Оросыг гол төлөв Оросын вангуудаар дамжуулан захирч байж. Харин тэгэхдээ зөвхөн цөөн тооны баскакууд буюу английн «резидент» маягийн элчин төлөөлөгчийг газар дээр нь суулгадаг байв. Англи улс нь эзэнт гүрнийхээ олон газар «резидент» суулгадаг байсан нь уг харьяат нутаг орноороо албан татвар тогтмол тэлүүлж байх, ерөнхий бодлогыг нь эзэнт гүрний эрх ашигт нийцүүлж байх зорилготой бөгөөд харин өдөр тутмын захиргааг орон нутгийн язгууртны мэдэлд өгч байсан юм.

Эсэргүүцэл үзүүлсэн вангуудыг Алтан Ордны засгийн газраас Монголын морин цэргийн залхаан цээрлүүлэх анги довтолгон буулгаж авдаг байжээ. Тэр үед Алтан Ордны төв нь Ижил мөрний адаг дахь Сарайд байрлаж байв. Алтан Орд ба нөгөө талаас Оросын нутаг хошуудын хоорондох үл эцэслэх улс төрийн тохуу наадмын хүчинд зарим нь ч бүр хождог байжээ. Хожоотой байсны нэг нь Москва юм.

Оросын үндэсний их баатаруудын нэг болох Невийн Александр баруун талд Швед, Тивтоны морин цэрэгтэй тулалдаж гавьяа байгуулсан хирнээ Монголчуудтай хэзээ ч тулалдсангүй, харин тэдний эзэн эрхийг төвөггүй хүлээсэн билээ. Тэр Монголын эрхшээлийг хүлээсэн дипломат алхамынхаа хүчинд Новгород хот улсыг Монголчуудын дайралтаас аварсан. Энэ бол урвалт биш реализм байж болох бөгөөд нөгөөтэйгүүр түүх бол тэр аяараа зөвхөн өдөөр бичсэн зураг биш гэдгийг харуулж байна.

Монголын байлдан дагуулалтын эхэн үе хүн амыг хүртэл цөөрүүлж, эмх замбараагүй болгосноороо түүхэнд тэмдэглэгдсэн үе боловч Оросууд хожим Их эзэнт улсын хэсэг нь болсноос олон талын ашиг олж ялангуяа арилжаа наймаа хөгжүүлэх болжээ. Монголчууд Хятад, Персийг захирч Алтан Ордны улс Хятад Персийн худалдааны зангилгааг гартаа оруулж Хар далай, Балтийн тэнгисийн Ганзитик (гааль) хот улсуудыг ноёрхож байлаа. Худалдаа арилжаа өрнөв. Хотууд сүндэрлэв. 1000 жил гаруйн хугацаанд анх удаа Марко Поло шиг Венецээс Бээжин хүртэл аялал жуулчлал хийх явдал нээгдлээ. Гэвч 14-р зууны дунд үеэс Орос Алтан ордны улсуудын олон тооны хотыг хар үхэл (тахал) нөмөрч хүн ам нь хиарснаас болон сүүл хирдээ Монголын хамгийн овжин хаан (байлдан дагуулагч) Төмөр буюу Тамерланы үед эмх цэгцээ алдсаны уршгаар дээрх өөдрөг үзэгдэл нь алдагдахад хүрчээ.

Алтан Ордны улсыг Казань, Астрахань зэрэг жижиг улсууд залгамжилж тэдгээр нь сүүлдээ Орос улсыг сэхэл олж сэргэн мандах үед түүнд шингэсэн болно. Энэ нь одоогийн ой шугуйт ба тал хээрийн Оросын дунд харилцан ойлголцох өв үлдээсэн төдийгүй, Орос, Монгол угсаатнууд харилцан ураг холбох болгожээ. Монголчууд Орост болон хаана л байсан газраа шашин шүтээн хэрэглэсээр байв. Алтан Ордны улс Лалын шашинд орсноос хойш ч тэр ёсоо алдсангүй. Энэ нь тэд Оросын цэвэр Христосын лам нарын үйл ажиллагааг хүлээж байсны гэрч болно. Гэтэл тэр үеийн түүхийг бичиг цаг ирэхэд тийнхүү аль ч шашныг тэвчих хандлага хийгээд Монголын захиргаанаас олдсон бүхий л ашиг сэлт нь Сталины үеийн турш их газар

авсан Оросын түүхийн гоёч, сүржин бичлэгийн далайд живжээ. Европ-Азийн түүхийн энэхүү эгзэгтэй үеийн тухай Англи хэлээр тун ч хомс бичигдсэн байх нь ул үндэстэй эх сурвалж маш бага үлдсэнтэй зарим талаар холбоотой биз ээ. Галперины хувьд бол материалаа бузгай мэдэж байвч бичих авъяас ядмаг нь харамсалтай юм. Тэрээр дундад зууны үеийн Оросын түүхчдийн чадал чансааг чамалсан атлаа тэдгээр «Номтон»-ы нэг адил давтаж нуруушсан, хэт дэвэргэсэн газар зөндөө байна. Нөгөөтэйгүүр орчин үеийн эх зохиолоос олж болох байсан зарим өнгө аяс ч золгүйгээр орхигдсон тал байна. Бас нэг үгүйлэгдэж байгаа зүйл бол Монголын (байлдан дагуулалтаас) өмнөх үеийн Оросын байдал, тэр үед Хятад, Перс болон Византи, Сельжук, Отманы Түрэг, Өрнөд Европын ертөнцөд юу болж байсан тухай юм.

Эдгээр нь уг номыг илүү авъяаслаг зохиогчдын гарт байх битгий хэл мэргэжлийн бус уншигчдад ч сонирхол маш багатай болгожээ. Артур Коестлер Хазаруудыг шоовдор овогт оруулсан шиг Монголчуудыг хэн тэгж чадах билээ. Хазарууд нь угтаа Түрэг угсааны нүүдэлчид байжээ. Тэд суурьшлыг олж улмаар Еврейн шашин (Иудиазм)-нд орсон нь эцэстээ Орос болон Дорнод Европын еврейчүүдийн гарч ирэх эх үндэс болжээ. 7 ба 10-р зууны хооронд Хазарын хаант улс ихэд хүчирхэг болж Алтан Ордны улс шиг л Ижил мөрний адаг Днепр хоёрын дундах тал нутгаар төвлөрөн сууж байжээ.

Филип Боуринг Гонконг-д гардаг «ФИЭР» сэтгүүлийн
1987 оны 12-р сарын 10-ны дугаараас **Э. Пунцаг** орчуулав.

ТҮҮХТ ХҮМҮҮСИЙН ОЙ

ХЯТАДЫН ХУВСГАЛЫН ОНОЛЧ
(Цюй Цюбо-гийн мэндэлсний 90 жилийн ойд)

Ч. Эрдэнэбаяр

1917 онд Зөвлөлт Орос Улсад ялан мандсан аугаа их октябрийн социалист хувьсгал нь дорно дахины дарлагдан мөлжигдсэн сая сая ард түмнийг цочроосон хувьсгалт их гэрэл гэгээг түгээлээ. Октябрийн хувьсгалын нөлөөгөөр 1920-иод оноос дотоод дахь феодал газрын эзэд, хөрөнгөтөн нар хийгээд гадаадын империалистуудын давхар дарлалд талхилагдсан Хятадын ард түмний үндэсний хувьсгалт ухамсар сэргэн дээшилж, хуучин нийгмийн харгис бурангуй ёсыг халж өөрчлөх бодолтой дэвшилтэт хувьсгалт үзэлтэн нар олноор төрөх болсон юм. Тэдгээрийн тоонд Хятадын хувьсгалын онолч, марксист-ленинист сургаалыг Хятадад түгээн дэлгэрүүлэгч, Олон Улсын Коммунист Хөдөлгөөний болоод Хятадын Коммунист намын нэрт зүтгэлтэн Цюй Цюбо зүй ёсоор ордог.